

ХЯТАДЫН УЛАМЖЛАЛТ БАЯРУУД

А.Батцэцэг¹

Хятадын хуримын ёс

Хятад улс бол урт удаан түүх, өргөн уудам газар нутагтай гэдгийг хэн хүнгүй мэднэ. Ураг хуримын ёсны талаар эрт дээд үеэс өнөөг хүртэл өөрчлөгдөн хувирсаар ирсэн боловч хуримын ёслол нь өргөн их, хөл хөгжөөнтөй, баяр баяслаар дүүрэн, өлзий дэмбэрэлтэй баяр юм. Хятадын эртний ураг хуримын ёс нь зургаан журамтай байжээ. Үүнийг “зургаан ёс” гэдэг бөгөөд тухайлбал, ураг дурьдах, бэлэг хүргэж ураг тогтох, бэр буулгах зэрэг юм. Эрт дээр үеэсээ эрэгтэйн талын аль нэг хүнд охин таалагдвал зууч явуулж ураг гуйлгуулдаг байжээ. Эрэгтэй тал нь зуучид бэлэг сэлт өгдөг бөгөөд энэ зуучаараа охины гэрт бэлэг хүргүүлдэг. Зууч нь хоёр залуугийн нэр, насыг бичсэн хуудас солилцдог. Хэрэв хоёр тал дуртай байвал харилцан айлчилж, эрэгтэйд тал нь сайн өдөр сонгож, эмэгтэйн гэрт очиж эмэгтэй талын байдлыг судалдаг. Жишээлбэл охины талын гэрийн амьдралын байдал, охины зан ааль, зүс царай зэргийг анхаардаг бөгөөд эмэгтэй тал нь ч эрэгтэйн гэрт очиж үздэг байжээ. Эрт үеэсээ эмэгтэй хүн эрэгтэйн гэрт очиж ирээдүйн нөхрөө харж болдоггүй байжээ. Одоо бол харин яг эсэргээрээ эмэгтэй нь заавал нөхөр болох гэж байгаа залуугаа очиж үздэг болжээ. Бээжин орчмын нутгаар эмэгтэй болон аав ээж нь эрэгтэйн гэрт зочлоход хүрвэл энэ ураг хуримыг зөвшөөрснийг харуулж байдаг байна.

Ураг тогтох буюу сүй тавих явдал бол ураг хуримын ёсны чухал хэсэг болно. Энэ нь хэдийгээр ард олны зан заншил боловч амьдрал дээр хуулийн дагуу үүргээ гүйцэтгэж байдаг. Ураг барилдахад эрэгтэйн тал нь эмэгтэйн гэрт инж, бэлэг хүргэдэг. Хятадын өмнөд нутгийн Вэнжөү хотод хүмүүс хос бөгж хүргэж бүрэн бүтэн байхыг бэлгэшээдэг. Эртний дүрс үсэгт энэ нь өнө мөнхийг харуулж, ураг хуримын явдал өөрчлөгдөхгүй гэснийг илтгэдэг байна.

Уламжлалт ёс заншлаар бол ураг барилдах буюу сүй тавьсныг дахиж өөрчилж болдоггүй, өөр хүнтэй ураг хуримын талаар дахин ярьж болдоггүй, ураг барилдах нь ёс заншлын хуулиар бататгадаг байна. Хоёр тал шаардлага бүхий ёс журмыг гүйцэтгэсний дараа жинхэнэ хурим найр хийж бэр буулгах шатандаа орно. Энэ бол бүх ураг хуримын ёсны хамгийн төвөгтөй, хамгийн хөл хөдөлгөөн ихтэй үйл юм.

Бэр буулгах өдөр шинэ бэр нь бэлгэ дэмбэрэл, баяр баясгаланг бэлгэдсэн улаан өнгийн хувцас өмсдөг (одоо бол цагаан хуримын даашинз өмсөх болжээ). Шинэ бэр нь төрхмөөсөө явахдаа гэр орноо занан, салж ядан уйлдаг. Шинэ бэр хадмындаа ирсний

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш

дараа хуримын ёслол эхэлнэ. Зарим нутагт эмэгтэйн тал хашаандаа гал түлж муу муухай зүйлийг шатааж, шинэ залуу хосын аз жаргалыг ерөөдөг. Дараа нь хуримын ёслолоо эхэлж, хоёр залуу тэнгэр газарт мөргөн, эцэг эхдээ мөргөж, харилцан ёслоно. Дараа нь бас хундага зөрүүлэн архи ууна. Шинэ өрөөнд хоёр залуу харилцан үсээ бэлгэлж нөхөр гэргийн үүрдийн дурсгал болгон хамт хадгална.

Хуримын ёслолын оргил бол мэдээж найрын ширээ юм. Хуриманд оролцсон хүн бүхэн баярын архи уудаг. Энэ хуримыг хүмүүс маш чухалд үзэж чадах ядахаараа бэлтгэдэг. Хуриман дээрээ хуримлагч хоёр зочин гийчдэд архи барьж хүндэтгэл үзүүлнэ. Шинэ бэрийн өрөөг цэгцлэх нь хуримын ёслолын хамгийн сүүлчийн ажиллагаа болно. Хүмүүс янз бүрийн аргаар шинэ хосуудаар тоглох нөхөрсөг тоглоом хийдэг ба эсвэл шинэ хосуудаар тоглолт хийлгэдэг. Үүний зорилго нь хуримыг улам хөөр хөгжөөнтэй болгож, шинэ хосуудад мартагдашгүй сэтгэгдэл үлдээх явдал юм.

Ханш нээх ёслол

Жил болгон урьхан хавар ирж, түмэн бодис амилан сэргэх үед Хятадын ард иргэд он удаан жилийн түүхтэй уламжлалт баяраа угтдаг. Ханш нээх бол мөн Хятадын билгийн улирлын 24 цагийн нэг юм. Нийтийн тооллоор тооцвол ерөнхийдээ 4-р сарын эхээр тохиодог. Энэ өдөр хүмүүс хээр хөдөө очиж, ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн өвөг дээдсээ тахиж онгон булшийг нь цэвэрлэн шүүрдэх буюу салхинд гарч, удан мөчир хугалан гэрийн үүдэндээ хатгадаг. Хятадын зарим газарт ханш нээх"-ийг "чөтгөрийн баяр" гэж нэрлэдэг. Энэ нь мөн нас барсан хүмүүсээ тахиж санааг агуулж байгаа юм. Ханш нээх үеэр хүмүүс өвөг дээдсийн онгон булшин дээр очин өвс хамхуулыг нь арилган шинэ шороо нэмж, хүж зул асаан цаасан зоос шатааж, мөргөж сөгдөн дурсан гашуудаж байгаа сэтгэлээ илэрхийлдэг. Домог ярианаас үзвэл, ханш нээх заншил Хань улсын үед манай тооллоос өмнөх 206-манай тооллын 220) үүсч Мин, Чин улсын үед онгон булш шүүрдэж, хүмүүс цаасан зоос шатаах төдийгүй, олон төрлийн хоол зууш хийж тахиж байсан байна. Ханш нээх заншил нь өнөөг хүртэл уламжлагдаж ирсэн боловч арга хэлбэр нь өөрчлөгдөх болсон байна. Хүмүүс өвөг дээдсийн онгон булшийг цэвэрлэн тахихаар барахгүй, үй олноороо үрэгдсэн баатруудын бунханд очиж цэцэг өргөж тэднийг дурсан санагалздаг болжээ. Ханш нээх нь урин хаврын цагт тохиодог болохоор олон жилийн хугацаанд хүн ард хөдөө хээр явж салхинд гарах нь элбэг. Охид эмэгтэйчүүд хөдөө хээр гарч ногоо ургамал түүж банш бууз чимхдэг. Ханш нээх үеэр хүмүүс мөн цаасан шувуу нисгэх, олс татах, дүүжин наадах зэргээр нааддаг заншилтай. Эртний үед хүмүүс ханш нээх үеэр бас мод тарих заншилтай байсан байна.

Гал тахиж ёс

Хятадын ард түмэн билгийн улирлын 12-р сарын 23-ны өдөр гал тахиж, галын бурхандаа талархах заншил бий болоод 2000 гаруй жил болж байна. Галын бурхан бол эртний домог ярианы нэг сахиус юм. Тэр бол тэнгэрийн хааны айл өрх болгонд илгээсэн түшмэл юм. Иймээс хүмүүс түүнээс айж сүрдэх нь ч элбэг. Галын бурхандаа дэвжин дээшлэхийн төлөө жил болгон галын бурхан тахиж ёс бий болжээ. Үүний тухай олон арван сонирхолтой сайхан үлгэр домог байдаг. Эрт урьд цагт Жан Шэн гэдэг баян хүн Дин Шян гэдэг царайлаг хөөрхөн мэргэн ухаантай гэргийтэйгээ эе эвтэй жаргалтай

амьдарч байжээ. Нэг өдөр Жан Шэн гадуур наймаа хийж явж байгаад Хай Тан гэдэг бас нэг хөөрхөн хүүхэнтэй танилцаж түүнд дурлажээ. Хай Тан ч Жан Шэнгийн баян тарганыг мэдээд дуртай нь аргагүй байжээ. Ингээд Жан Шэн удалгүй Хай Танг татвар хатан болгон буулгаж авав. Дин Шян өөрөөс нь царайлаг авааль хатантай болсон болохоор Хай Танд атаархан хорсож Жан Шэнг шахаж байгаад төрхөмд нь буцаалгаж гэрээсээ хөөж гаргажээ. Түүнээс хойш Жан Шэн болон Хай Тан өдөржин архи дан жаргах болж хоёр жил ч бололгүй эд хөрөнгөө барж модоо барьсан гуйлгачин болжээ. Жан Шэн ядуурсныг үзээд Хай Тан түүнийг хаяж өөр эрд гарсан байлаа. Ингээд Жан Шэн ганцаараа хоцорсон бөгөөд өөрөө юу ч хийж бүтээж чадахгүй, урьд нь цөмийг мэргэн хатан Дин Шян нь хийж байсан болохоор гуйлгачин болох нэг л зам түүнд үлджээ. Их цас орсон нэг хүйтэн өдөр Жан Шэн өлсөж дааран нэг баян айлын үүдэн дээр ирээд муужирч унажээ. Баян айлын зарц түүнийг олоод гэрийн эзэгтэйд хэлж түүнийг гал тогооны өрөөндөө оруулж гэнэ. Ингээд энэ баян айлын гэрийн эзэгтэй бүсгүй болоод байсан Дин Шян ирж харвал түүний хуучин нөхөр Жан Шэн байжээ. Жан Шэн төрхөмд нь буцаасан хуучин гэргийгээ таниад ичихдээ зуухан дотор оржээ. Дин Шян гараад дахин орж иртэл Жан Шэн алга болсон тул ихэд гайхан хайтал зууханд орж шатан нас барсан байжээ. Дин Шян гомдон гашуудсаар байгаад нэг их удалгүй нас баржээ. Тэнгэрийн хаан энэ хэргийг мэдээд Жан Шэнг буруутгасан боловч өөрийн буруугаа хүлээх зоригтой байсан гэж үнэлэн галын бурхан болгосон гэнэ. Хожим нь хүмүүс Дин Шянг галын бурхан болгон тахиx болсон байна. Эртний хүмүүс галын бурхан тэнгэрийн хаанд өөрийг нь муу хэлэхээс айж улаан буудайгаар хийсэн чихрээр галын бурхнаа тахидаг байжээ. Энэ чихэр нь маш нялцгай, шүдэнд наалддаг болохоор галын бурхан идвэл шүдэнд нь наалдаж үг хэлэх аргагүй болно гэж үздэг байна.

Идээ ундааны зан заншил

Савх

Дэлхий дээр хоол идэх гурван зүйлийн арга байдаг. Хүн төрөлхтөний 40 хувь нь шууд гараараа барьж, 30 хувь нь сэрээ халбага хэрэглэдэг бол үлдсэн 30 хувь нь савх хэрэглэдэг байна.

Савх бол хятадуудын нэг том нээлт юм. Урьд эрт 3000 гаруй жилийн өмнө Инь Шан улсын үед савх хэрэглэж байсан байна. Гэвч тэр үед савхыг Куай-з гэж хэлдэггүй байжээ. Эртний ном судраас үзвэл тэр үед хүмүүс савхыг Жү буюу Жя гэж хэлж байжээ. Манай тооллын 6, 7-р зууны үед савхыг хүмүүс Жинь гэж нэрэлж байжээ. Куай-з гэдэг үг чухам хэжээ би болсон бэ ? Баримт бичгээс үзвэл Хятадын зүүн өмнөд нутгийн хувьсгийн ярианд савхны эртний дуудлага Жү нь зогсохын Жүтай адил байдаг. Гол мөрөн дээр усан онгоцоор явдаг хүмүүс зогсох гэсэн үгийг их цээрэлдэг байсан болохоор зогсохын эсрэг Куай түргэн гэдэг үгээр орлуулсан юм байна. Савхыг хулсаар хийдэг учраас манай тооллын 10-р зууны Сүн улсын үед хүмүүс энэ Куай үсгийн дээр хулс гэсэн утгатай Жү толгой нэмээд Куай-з болгосон байна. Түүнээс хойш хувьс одоо болтол Куай-з савх гэж нэрлэсээр байна.

Балар эртний хүмүүс гал дээр юм шарж идэхдээ модон салаа буюу хулсаар хавчиж шарвал гар халахгүй бөгөөд халуунаар нь идэж болох тул үүнээс улбаалан савх бий болсон гэж үздэг. Савхны бүтэц тун хялбар, хоёр ширхэг мод буюу хулс байхад л болоо. Үзүүр хэсэгтээ нарийн, дээд тал нь дөрвөлжин болохоор барихад амар, амархан унахгүй, уруул амыг гэмтээхгүй байдаг. Савх Японд уламжлагдан орсны дараа Япончууд савхыг хэрэглээндээ зохицуулан улам боловсронгуй болгосон байна.

Савхыг хийхэд их амархан боловч хятадууд хийх материал болон сийлбэр хээ зэрэг гаргаж урлах талаар бас их ухаан гаргажээ. 2000 гаруй жилийн өмнө зааны соёогоор хийсэн савх болон хүрэлээр цутгаж хийсэн савх хэрэглэж байжээ. 6, 7-р зууны үед хааны ордон, ноёд түшмэдийн гэр болон баян айлд алт, мөнгө, хаш, шүрээр чимсэн савх хэрэглэж байжээ. Зарим нь савхан үзүүрийг мөнгөөр хийж хоолонд хортой хэсгийг шалгаж, хоолонд хэрэв хор хийсэн байвал мөнгө нь харлах буюу ногоордог байна. Савх нь Хятадуудын амьдралд маш чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн байна. Зарим нутагт охиноо хүргэнд мордуулахдаа заавал залуу хосд зориулан хоёр хос аяга, савх өгдэг бөгөөд түүнийгээ улаан утсаар холбож “үр хүүхдийн аяга” гэж нэрлэдэг. Энэ нь шинэ хосын шинэ амьдрал эхэлж байгааг илэрхийлэхийн хамт савхны Куай-з гэсэн үгний Куай түргэн гэдэг адил дуудлагыг ашиглан эртхэн үр хүүхэдтэй болохыг хүсэн ерөөсөн санааг илэрхийлдэг. Хятадын умард нутгийн хөдөө тосгонд залуу хос хурим хийсний дараа төрөл садан нь залуу хосын өрөөний цонхоор савх шидэж, аз жаргал сайн сайхныг хүсэн ерөөж эртхэн үр хүүхэдтэй болохын бэлгэдэл болгодог. Савх нь хоёр ширхэг мод төдий боловч түүнийг боловсронгуй эзэмшиж хэрэглэхэд бас дадлага хэрэгтэй байдаг.

Хятадуудын савх хэрэглэх ур чадварыг гадаадынхан ихэд гайхдаг. Барууны оронд цаашлаад савх хэрэглэхийг сургадаг “бэлтгэлийн төв” байгуулсан нь ч бий. Савх хэрэглэхэд хүний биеийн 30 гаруй үе, 50 гаруй хэсэг булчин хөдлөх тул гар уран болох болон тархины бойжилтонд тустай гэж анагаах ухааны мэргэжилтэнгүүд үздэг байна. Хятад улс бол савхны эх нутаг, гэвч дэлхийн анхны савхны музей Германд байдаг. Энэ музейд алт, мөнгө, эрдэнийн чулуу болон амьтны яс зэрэг олон төрлийн материалаар хийсэн 10 мянга гаруй хос савх байдаг бөгөөд улс орон, газар нутгийн адил бус түүхэн үед хийгдсэн юм байна.